

ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН
ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХАД ТАВИГДАХ
ҮНДСЭН ШААРДЛАГУУД БА ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
ХҮЛЭЭН АВАХ ДОТООД ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйл

1. Уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элементийг агуулсан эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан уул уурхайн (цацраг идэвхт ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төсөл хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох дараахь 3 төрлийн баримт бичиг байна.

1.1. Төсөл хэрэгжүүлэх урьдчилсан үнэлгээ:

1.1.1. Хайгуулын ажлаар илрүүлсэн эрдэс баялаг дээр тулгуурлан цацраг идэвхт ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах уул уурхайн төсөл хэрэгжүүлэх эдийн засгийн боломжийн талаар суурь судалгаа хийж урьдчилсан үнэлгээ өгөх зориулалтаар хийгдэнэ. Холбогдох аргачлалын дагуу хийгдсэн хайгуулын ажлын үр дүнгээр олж авсан мэдээлэл дээр үндэслэн эрдэс баялгийн хэлбэр хэмжээ, бүрдэл, агуулга, чанар, геологийн тогтцыг тодорхойлсон байна. Төсөл хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох хязгаарлагдмал хэмжээний туршилт, инженерийн болон эдийн засгийн үр ашгийн тооцоо хийсэн байна.

1.2. Техник-эдийн засгийн үнэлгээ:

1.2.1. Ордын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зорилгоор хайгуулын ажлаар тогтоосон эрдэс баялаг дээр тулгуурлан уул уурхайн (цацраг идэвхт ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төсөл хэрэгжүүлэх боломжит хувилбаруудын эдийн засгийн үр ашгийг тооцсон судалгаа юм. Уурхай, уулын үйлдвэрийн техник, технологийн сонголт, инженерийн шийдэл, эрх зүй, үйл ажиллагаа, эдийн засаг, нийгэм, байгаль орчны болон холбогдох бусад хүчин зүйлсийн санхүүгийн дүн шинжилгээг цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг бүртгэх түвшинд боломжит хувилбаруудаар хийсэн байна;

1.2.2. Төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үзүүлэх экологийн хохирлыг холбогдох аргачлалын дагуу тооцсон байна.

1.3. Төслийн техник-эдийн засгийн үндэслэл:

1.3.1. Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах уул уурхайн төслийн санхүүжилтийг шийдэхэд чиглэгдсэн ордын геологи, инженерийн шийдэл, эрх зүй, үйл ажиллагаа, эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад хүчин зүйлсийг нарийвчлан тооцсон дэлгэрэнгүй судалгаа хийсэн байна;

1.3.2. Ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна;

1.3.4. Орд ашиглах хугацаанд жил бүрийн гүйцэтгэх ажлын хэмжээ, эдийн засгийн үзүүлэлтүүдийг техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан байна.

1.4. Цацраг идэвхт ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах технологи нь өргөн хүрээтэй туршилтын ажил дээр тулгуурласан, эдийн засгийн үнэлгээ нь нийт нөөцийг ашиглах жил бүрийн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын технологийн зардал ба татвар, санхүүгийн хуульд нийцүүлэн борлуулалтын орлого зэргийг тусгаж тооцсон бэлэн мөнгөний урсгал, мэдрэмжийн шинжилгээнд тулгуурласан байна.

Хоёр. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах

2.1. Техник эдийн засгийн үнэлгээ, үндэслэлийг геологи, уул уурхайн болон цөмийн эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төслийн байгууллага, аж ахуйн нэгж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий Монгол Улсын зөвлөх инженер боловсруулна.

2.2. Гадаадын байгууллагын боловсруулсан техник эдийн засгийн үнэлгээ, үндэслэлийг энэ зааврын 2.1-д заасан этгээд орчуулж, агуулга хэлбэрийн хувьд мөрдөгдөж буй зааварт нийцүүлэн бэлтгэсэн байна.

2.3. Нийтлэг зүйлийн 1.1, 1.2 ба 1.3-т заасан үнэлгээ, үндэслэл гүйцэтгэхэд тавигдах үндсэн шаардлага, зайлшгүй оруулбал зохих үзүүлэлтүүдийг 1-р хүснэгтэд харуулав. Холбогдох зургуудыг компьютерийн мэргэжлийн программын тусламжтай үйлдсэн байна.

Гурав. Техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах

3.1. Цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг захиалж хийлгэсэн аж ахуйн нэгж нь түүний хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийсэн тус бүр нэг хувийг Цөмийн энергийн газарт ирүүлэх бөгөөд тус газар нь санал, дүгнэлтээ гарган Эрдэс баялгийн зөвлөлд уг техник эдийн засгийн үндэслэлийн хамт хүргүүлнэ.

3.2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл техник эдийн засгийн үндэслэл хүлээн аваад тус зөвлөлийн хурлаар хэлэлцэн түүнийг ашиглах зөвшөөрлийг өгөх эсэх шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Орд ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд ерөнхий болон хэсэгчилсэн байдлаар хөндлөнгийн шинжилгээ хийлгэж болно.

3.3. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд техник-эдийн засгийн үндэслэлийг захиалагч байгууллага танилцуулах бөгөөд гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгчийг заавал байлцуулна.

3.4. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс тухайн техник-эдийн засгийн үндэслэлд шинжээчийн дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзвэл холбогдох зардлыг хэлэлцүүлж байгаа аж ахуйн нэгж хариуцна.

Дөрөв. Техник-эдийн засгийн үндэслэлийг хадгалах,
ашиглах ба шинэчлэн боловсруулах

4.1. Техник-эдийн засгийн үндэслэлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тус бүр гурван хувь үйлдсэн байх бөгөөд захиалагч, гүйцэтгэгч байгууллага ба Цөмийн энергийн газрын Цөмийн материалын хэлтэст тус тус нэг хувийг хадгална.

4.2. Цөмийн материалын хэлтэс хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн хэвлэмэл хувийг Цөмийн энергийн газрын архивт шилжүүлэх бөгөөд цахим хувилбарыг орд ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ашиглана.

4.3. Цөмийн материалын хэлтэс нь техник-эдийн засгийн үндэслэлийг захиалагчийн хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна.

4.4. Уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд технологи, эдийн засгийн өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэгч байгууллага техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ.

4.5. Техник-эдийн засгийн үндэслэлийн хэрэгжилтийг жил бүрийн тайлан, уулын ажлын төлөвлөгөөгөөр дамжуулан хянах ажлыг Цөмийн материалын хэлтэс хэрэгжүүлнэ.

4.6. Ашиглалтын явцад техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан захын агуулга, кондици, нөөц зэрэг голлох үзүүлэлтүүдэд бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханшийн хэлбэлзэл, үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлт зэргээс шалтгаалан гарах бага хэмжээний өөрчлөлтийг төсөл хэрэгжүүлэгч компани жил бүрийн эцэст шинэчлэн тогтоож, ирэх жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган Цөмийн материалын хэлтэст мэдэгдэж байх.

4.7. Энэ зааврын 4.6-д дурьдсан үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтийг шаардлагатай гэж үзвэл Цөмийн материалын хэлтэс нөөцийг улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ.

**ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН ОРД АШИГЛАХ ТЕХНИК-ЭДИЙН
ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Үзүүлэлтүүд	Төсөл хэрэгжүүлэх урьдчилсан үнэлгээ	Техник, эдийн засгийн үнэлгээ	Техник-эдийн засгийн үндэслэл
Судалгааны түвшин	Боломжтой хүчин зүйлсийг урьдчилан үнэлнэ	Инженерийн судалгаанд үндэслэнэ	Дэлгэрэнгүй инженерийн шийдлийн тооцоонд үндэслэнэ
Эрдэс баялаг, хүдрийн нөөц	Хайгуулын ажлаар илрүүлсэн эрдэс баялаг	Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлж нөөцөд бүртгүүлэх шаардлага	Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлж бүртгүүлсэн хүдрийн нөөц байна
Олборлолт, баяжуулалтын хүчин чадал	Таамаг тооцоо хийсэн байна	Нөөц бүртгүүлэхэд шаардлагатай урьдчилсан хүчин чадал	Нарийвчлан тооцсон хүчин чадал байна
Байгаль орчныг хамгаалах шаардлагууд болон хуулийн дагуу шаардлагатай зөвшөөрлүүд	Судалж урьдчилсан жагсаалт гаргасан байна	Байна	Байна
Уурхай байгуулах болон уурхайн ажиллах хугацаа	Төсөөлөл гаргасан байна	Байна	Байна
Металл (ашигт агууламж) авалт	Жишиг судалгаанд тулгуурласан байна	Байна	Байна
Хөрөнгө оруулалтын хэмжээ	Таамаг тооцоо	Байна	Байна
Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин	Таамаг тооцоо хийсэн байна	Байна	Байна

ТАНИЛЦУУЛГА (1)

Тусгай зөвшөөрлийн хуулбар, жагсаалт	Байна	Байна	Байна
Тусгай зөвшөөрөлтэй талбайн газар зүйн солбицол бүхий зураг	Байна	Байна	Байна

Байр зүйн зураг	Байна	Байна	Байна
Тусгай зөвшөөрөлтэй талбайн нарийвчилсан топо зураглал	Хайгуулын ажлын явцад хийгдсэн байна	Байна	Байна
Цаг уурын төлөв байдал	Хайгуулын ажлын явцад төсөөлөл авсан байна	Байна	Байна
Ордын судлагдсан түүх	Байна	Байна	Байна
Ордыг ашиглаж байсан бол нөөц ашиглалтын тооцоо, судалгаа	Байна	Байна	Байна

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

Геологийн зургууд	Байна	Байна	Байна
Геологийн зүсэлтүүд	Байна	Байна	Байна
Өрмийн цооногийн байршлын зураг	Байна	Байна	Байна
Дээжлэлтийн гүн	Байна	Байна	Байна
Хяналтын дээжлэлтийн гүн	Байна	Байна	Байна
Нөөц тооцсон дэвсгэр зураг	Байна	Байна	Байна
Нийт дээжлэлт ба агуулгын хэлбэлзэл	Байна	Байна	Байна
Нөөцийн тооцоо ба аргачлал	Байна	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу

ОЛБОРЛОЛТ

Олборлох нөөцийн үнэлгээний үзүүлэлтүүд	Хайгуулын ажлын үр дүн	Туршилтын үр дүн	Туршилтын үр дүнгээр
Захын агуулга тооцсон аргачлал, томъёо	Судалгаанд тулгуурласан	Байна	Байна
Олборлох нөөцийн тооцоо, үнэлгээ	Таамаг тооцоо	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу
Уурхайн ерөнхий бүтцийн дэвсгэр зураг	Тойм зураг	Байна	Байна
Уурхайн эцсийн ерөнхий дүр	Тойм зураг	Байна	Байна

Жил бүрийн олборлолтын хүрээ, мөргөцгийн байршил	Тойм зураг	Байна	Байна
Жил бүрийн олборлолтын хэмжээ, хөрс хуулалт	Ордын нөөцийг багцаалан хуваасан байна	Байна	Байна
Хөрөнгө оруулалтын тооцоо, хайгуулын ажлын зардал	Анхан шатны судалгаа хийсэн дүн	30 хувийн нарийвчлалтай байна	20 хүртэл хувийн нарийвчлалтай байна

БАЯЖУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Дээж авалт, шинжилгээний үр дүн	Урьчилсан үр дүн, өгөгдлүүд	Байна	Нарийвчилсан үр дүн
Баяжуулалт, боловсруулалтын үзүүлэлтүүд	Инженерчлэлийн анхан шатны түвшинд	Байна	Байна
Тоног төхөөрөмжийн жагсаалт	Байна	Байна	Байна
Ашиглах материалын жагсаалт	Анхан шатны судалгаа хийсэн дүн	Байна	Байна
Технологийн схем	Энгийн схем	Байна	Байна
Ажиллах хүчний жагсаалт	Таамаг тооцоо	Байна	Байна
Талбайн зураг	Энгийн схем	Байна	Байна
Үйлдвэрийн талбайн нэгдсэн зураг	Энгийн схем	Байна	Байна
Хөрөнгө оруулалт ба ашиглалтын зардал	Таамаг тооцоо	30 хүртэл хувийн нарийвчлалтай байна	20 хүртэл хувийн нарийвчлалтай байна.
Шүүх, тунгаах, хатааж цэвэршүүлэх эцсийн боловсруулалт хийх зардал	Анхан шатны судалгаа хийсэн дүн	Байна	Байна

ДЭД БҮТЭЦ БА УДИРДЛАГА

Дэд бүтцийн байгууламжийн жагсаалт	Төсөөлөл	Байна	Байна
Эрчим хүч, усны хангамжийн үзүүлэлтүүд	Төсөөлөл	Байна	Байна
Засвар үйлчилгээний удирдлагын систем	Төсөөлөл	Байна	Байна
Үйлдвэрлэлийн нэгжүүдийн нэгдсэн зураг	Төсөөлсөн схем	Байна	Байна

Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, удирдлагын зардлын хэмжээ /үйл ажиллагааны зардал болон ашиглалтын өмнөх зардал орно/	Таамаг тооцоо	30 хүртэл хувийн нарийвчлалтай байна	20 хүртэл хувийн нарийвчлалтай байна
Ажиллах хүчний жагсаалт	-	Байна	Байна

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем	Төсөөлөл	Байна	Байна
Ашиглах зөвшөөрөл, дүрэм журмуудын жагсаалт	Байна	Байна	Байна
Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө	Төсөөлөл	Байна	Байна
Үйлдвэрийн хаягдлын аж ахуйн удирдлага	Төсөөлөл	Байна	Байна
Уусмал болон хортой бодисын хадгалалт, саармагжуулалт	Төсөөлөл	Байна	Байна
Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх	Төсөөлөл	Байна	Байна
Онцгой байдалд ажиллах арга хэмжээний	Төсөөлөл	Байна	Байна
Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоо	Таамаг тооцоо	30 хүртэл хувийн нарийвчлалтай	20 хүртэл хувийн нарийвчлалтай
Уурхайн хаалтын горимын төлөвлөгөө, зардлын тооцоо, хаалтын дараах хяналтын асуудлууд	Таамаг тооцоо	30 хүртэл хувийн нарийвчлалтай байна	20 хүртэл хувийн нарийвчлалтай байна

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэх хугацааны график	Таамаг тооцоо	Байна	Байна
------------------------------------	---------------	-------	-------

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ҮНЭЛГЭЭ

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	-	Байна	Байна
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад татварын орлого	-	Байна	Байна
Мөнгөн гүйлгээний төлөв	-	Байна	Байна
Мэдрэмжийн шинжилгээ	-	Байна	Байна